



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН СЭДЭВТ НИЙЦЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: УВА-2025/21-19/-ШТА-НА

Улаангом хот 2025 он

Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn

Аудитын менежер М.Бат-Амгалан

Утас: 70453317 Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Мөнхтогтох

Утас: 70453317 Цахим хаяг: munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор А.Нанжидмаа

Утас: 70453317 Цахим хаяг: nanjidmaaa@audit.gov.mn

Аудитор Т.Золоо

Утас: 70453317 Цахим хаяг: zoloot@audit.gov.mn

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	2
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	3
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Ахлах аудитор Ч.Мөнхтогтох	Бүлэг А. Төрийн хэмнэлтийн тухай хэрэгжилт хангалтгүй байна.	6
Аудитор Т.Золоо А.Нанжидмаа	<i>А.1. Хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.</i>	6
	<i>А.2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хуулийг мөрдөж ажиллах чиглэлийг хүргүүлсэн ч хэмнэлтийн бусад арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна.</i>	9
2025 оны 5 дугаар сар	Бүлэг Б. Хөрөнгө оруулалттай холбоотойгоороо хуульд заасан журмын хэрэгжилт хангалтгүй байна.	13
	<i>Б.1. Хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.</i>	13
	<i>Б.2. Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагааг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.</i>	15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг В. Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнтэй байгаа ч алдаа, зөрчил гарсаар байна.	17
	<i>В.1. Хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.</i>	17
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	<i>В.2. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсөвт хэмнэлт гарсан ч үр дүн хангалтгүй байна.</i>	18
	<i>В.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.</i>	19
	Дүгнэлт	21
	Холбогдох байгууллагын санал	22
	Аудитын газраас өгөх тайлбар	25
	Зөвлөмж	26

Товчилсон үгийн тайлал:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
НА	Нийцлийн аудит
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар.....	6
Хүснэгт 2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмнэлтийн бусад арга хэмжээ.....	9
Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны хэмнэлт, барьцаа дансанд байршуулсан мөнгө...13	13
Хүснэгт 4. Цахимаар зарласан худалдан авалт	16
Хүснэгт 5. ТЕЗ-ын батлагдсан төсөв гүйцэтгэл.....	20

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэлээ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх;
- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан эсэх;
- Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан эсэх;

Хамарсан хүрээ

Аудитыг төсөвт байгууллагуудад 2022, 2023 онд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнэж, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2024 оны үйл ажиллагааг түүвэрт хамруулж, холбогдох санхүүгийн баримт материалд үндэслэн хийлээ.

Хууль, хяналтын байгууллагууд болон шүүхээр хянан хэлэлцэгдэж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Арга зүй

Аудитад АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ч.Мөнхтогтох, аудитор А.Нанжидмаа, Т.Золоо нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий зүйл

Төрийн хэмнэлтийн тухай хууль нь 2022 онд анх батлагдсантай холбоотойгоор Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2022 онд 1 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 3 удаа тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2022 онд 274 байгууллагыг хамруулан 7,915.4 сая, 2023 онд 274 байгууллагыг хамруулж 2,568.9 сая, нийт 10,484.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж шийдвэрлэсэн байна.

БҮЛЭГ:А. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.**А.1. Хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалт Увс аймагт авто бааз одоог болтол байгуулагдаагүй байгаагаас шалтгаалан хэрэгжих боломжгүй байна. Төсвийн байгууллагууд өөрийн данс бүртгэлд байгаа тээврийн хэрэгслээр албан үүргээ гүйцэтгэж байна.

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-д заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 13/04 дүгээр “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор 287.3 сая төгрөгийн балансын үнэтэй 11 ширхэг тээврийн хэрэгсэл шилжүүлэх, 1,576.4 сая төгрөгийн балансын үнэтэй 70 ширхэг тээврийн хэрэгсэл татан төвлөрүүлэх шийдвэр гаргасан байна.

Татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 70 ширхэг тээврийн хэрэгслээс 13 ширхэг тээврийн хэрэгслийг ашиглагч байгууллагын зүгээс гаргасан засвар үйлчилгээ хийж ашиглах саналын дагуу үлдээж, 45 ширхэг тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 9 ширхэг тээврийн хэрэгслийг төрийн өмчит болон орон нутгийн төсөвт байгууллагад шилжүүлэн өгч, 3 ширхэг тээврийн хэрэгсэлд 8 удаа дуудлага худалдаа зарласан ч оролцогч оролцоогүй бөгөөд дахин дуудлага худалдаа зарлахаар байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ”, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэлтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан заасан байна.

Хүснэгт 1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарт шилжүүлсэн байдлыг харуулбал:

№	Байгууллага	Байгууллагын тоо	Тээврийн хэрэгслийн тоо	Тод дэвсгэр бүхий улсын дугаар авсан	Тод дэвсгэр бүхий улсын дугаар аваагүй
1	ТЕЗ-ийн харьяа	34	321	88	223
2	Төсвийн шууд захирагч	70	379	294	85
3	Төрийн өмчит ААН	5	57	47	10
Нийт		109	757	429	318

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт 757 тээврийн хэрэгслийн 318 буюу 42 хувь нь тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.

Тод дэвсгэр бүхий улсын дугаар аваагүй дээрх 318 тээврийн хэрэгслээс зарим тээврийн хэрэгслийг актлах санал хүргүүлсэн, бичиг баримтын зөрчилтэй, эвдэрч ашиглагдахгүй болсон зэрэг шалтгаантай тээврийн хэрэгсэл цөөнгүй байгаа ч, төсвийн захирагчийн зүгээс хуулийн хэрэгжилтийг хангуулаагүй зөрчил байна.

Иймд төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зүгээс тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарт шилжүүлэх шаардлагатай тээврийн хэрэгслийг хуульд заасны дагуу тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарт шилжүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно”, 5.3 дахь хэсэгт “Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно” гэж заасны дагуу Улаангом сумын Засаг дарга орон тооны 2 орлогч даргатай байсныг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Б/18 дугаар захирамжаар 1 орлогч даргыг чөлөөлсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.4 дэх хэсэгт “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно” гэж заасан байна.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт өөрчлөлт оруулан баталсан байна. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Б/34 дүгээр тушаалаар хяналт үнэлгээ хариуцсан менежерийг томилж үндсэн цалинг 1.9 сая төгрөгөөр, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Б/43 дугаар тушаалаар хүний нөөцийн бүтээмжийн менежерийг томилж үндсэн цалинг 1.8 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Дээрх асуудлыг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай холбоотой 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ❖ Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төв 0.7 сая, Эрүүл мэндийн газар 0.9 сая, нийт 1.6 сая төгрөгийн биеийн тамирын өмсгөл төсвөөс худалдан авсанд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Ойрад хөгжимт жүжгийн театр нь хөдөө сумдад хийсэн тоглолтын орлогыг Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаахгүйгээр хөндий зарлагдаж байгууллагын 57 ажилтанд нийт 3.3 сая төгрөгийн үнэ бүхий бомбор хувцас худалдан авсанд зөрчил арилгах албан шаардлага өгсөн.

Хуулийн 8 дугаар зүйлд хамаарах дээрх зөрчил давтагдаж гараагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заасан байхад Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын цалинг тогтоож, бусад албан хаагчдад олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төлөөлөн удирдах зөвлөл нь баталж байна.

Цаашид иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар бүтэц орон тоо, гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг батлахыг зөвлөмж болгов.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1 дэх заалтад “Гар утасны зардал”, 12.1.2 дахь заалтад “Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтуудтай холбоотойгоор 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 16.8 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 22.1 сая төгрөгийн 4 албан шаардлага, 1.2 сая төгрөгийн 1 зөвлөмж, 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.7 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 250.5 сая төгрөгийн 1 зөвлөмж, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 18.3 сая төгрөгийн 17 төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудит 2022 он

- ❖ Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар ажилтнуудад төсвийн хөрөнгөөр 0.2 сая, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 0.2 сая төгрөгийн гар утасны нэгж худалдан авч өгсөнд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар 3.3 сая төгрөгийг ажилчдын аялал зугаалгад, Завхан сумын Засаг даргын тамгын газар 0.3 сая төгрөгийг томилолтоор ирж ажилласан хүмүүсийн хоолны зардалд, Тариалан сумын Засаг даргын тамгын газар 3.0 сая төгрөгийг ажилчдын амралт сувилалд зориулж төсвийг үр ашиггүй зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь батлагдсан бүтэц, орон тоог хэтрүүлэн нярав-жолооч нэмж /шинээр томилогдсон албан хаагчид томилсон тушаал байхгүй/ ажиллуулан төсвөөс 4.2 сая төгрөгийн цалин олгож төрд хохирол учруулсанд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Прокурорын газрын түр чөлөөлөгдсөн нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ ашиглаж хуурамч баримт бүрдүүлэн өөртөө 3.9 сая, туслах ажилтанд 1.8 сая, нийт 5.7 сая төгрөгийн цалин илүү олгосонд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Улаангом сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч, нярав нь Улаангом сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэдэг бөгөөд Улаангом сумын Засаг даргын тамгын газар болон ИТХ-аас 0.4 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг давхардуулан авсанд зөрчил арилгах албан шаардлага өгсөн.
- ❖ “Увс АЗЗА” ТӨХК нь Баруун бүсийн авто зам, завсар арчлалт хариуцсан компаниудын ажилтан албан хаагч болон замчдын хооронд явагдах спортын тэмцээний зардалд 6.0 сая, тэмцээний хувцасны зардалд 1.2 сая, бэлтгэл сургуулилын зардалд 1 сая, Баян-Өлгий аймагт очиж тэмцээнд оролцох албан хаагчдын томилолтын зардалд 0.8 сая, нийт 8.9 сая төгрөгийг компанийн ТУЗ-ийн шийдвэргүйгээр, Соёл урлагийн газар нь 10.7 сая төгрөгийн 3290 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсанд зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.
- ❖ Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч нь ИТХ-ын нягтлан бодогчийн ажил хавсран гүйцэтгэдэг бөгөөд төсвөөс 1.3 сая төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг давхардуулан авсанд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудит 2023 он

- ❖ Соёл урлагийн газар нь “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцсон нэр бүхий 4 ажилтанд 1.2 сая төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосонд төлбөрийн акт тогтоосон.

- ❖ “Үйлдлээрээ үлгэрлэгч Увсчууд” аяны хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 1.2 сая, Өмнөговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 1.3 сая төгрөгийг хоолны зардалд тус тус зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн дансанд төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээнд 205.0 сая төгрөг батлагдсан байхад нэмж төсвийн тодотголоор Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, ажлын албаны албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, хурлын үйл ажиллагааг өргөжүүлэх, арга хэмжээний хөтөлбөрийн зардалд гэж 250.0 сая төгрөгийн санхүүжилтийг баталж зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудит 2024 он

- ❖ Төрийн захиргааны албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг олгохдоо Өлгий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 0.4 сая, Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар 0.8 сая, Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар 2.9 сая, Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 0.9 сая, Тэс сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 0.8 сая, Тэс сумын Засаг даргын тамгын газар 2.5 сая, Завхан сумын Засаг даргын тамгын газар 2.3 сая, Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар 0.8 сая, Бөхмөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 0.9 сая, нийт 12.2 сая төгрөгийг илүү, 0.1 сая төгрөгийг дутуу олгосонд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй албан хаагчид Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг 0.5 сая, Мал эмнэлгийн газар 1.1 сая, Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 0.7 сая, нийт 2.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

А.2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хуулийг мөрдөж ажиллах чиглэлийг хүргүүлсэн ч хэмнэлтийн бусад арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас харьяа төсвийн захирагч нарт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар дараах чиглэл хүргүүлжээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1/1017 дугаар захирамжаар “Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж ажиллах”-ыг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт,
- Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1/1223 дугаар захирамжаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон зардал, арга хэмжээг тусгахгүй байх чиглэл”-ийг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт,
- Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/2200 дугаар албан бичгээр “Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлаар хуулиар хориглосон арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх чиглэл”-ийг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт,
- Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 1/1282 дугаар албан бичгээр “Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон зардал, арга хэмжээг тусгахгүй байх чиглэл”-ийг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт тус тус хүргүүлсэн байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлээрх зардлын хэмнэлт, хэтрэлт дараах байдалтай байна.

Хүснэгт 2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022-2024 оны зардлын хэтрэлт, хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Эдийн засгийн ангилал	2022			2023			2024		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт Хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт Хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт Хэмнэлт
Гэрэл, цахилгаан	669.9	615.0	54.8	1,196.7	914.9	281.8	1,488.1	1,251.6	236.5
Түлш, халаалт	8,690.4	8,393.0	297.5	9,233.7	9,051.6	182.1	15,143.3	13,674.0	1,469.3
Цэвэр, бохир ус	301.2	216.9	84.3	447.2	321.0	126.2	1,397.7	1,007.5	390.2
Бичиг хэрэг	113.2	108.0	5.2	176.8	170.7	6.1	205.1	210.6	-5.5
Тээвэр, шатахуун	769.6	763.1	6.5	899.6	880.6	19.0	968.0	920.7	47.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	109.2	90.0	19.2	154.6	125.6	29.0	119.8	96.3	23.5
Дотоод албан томилолт	305.9	278.3	27.7	531.9	479.1	52.8	581.8	565.2	16.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	286.0	275.4	10.6	323.7	293.5	30.2	389.7	344.4	45.3

Эх сурвалж: /ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Дээрх судалгаанаас харахад аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас харьяа төсвийн захирагч нарт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар өгсөн чиглэл зохих үр дүнгээ өгч харьяа байгууллагууд батлагдсан төсвөө хэмнэж ажилласан байна.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.1 дэх заалтад “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэж заасан байна.

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “зохицуулах хорооны бүрэн эрх”, 9.1.4 “тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх”, 9.2 дахь хэсэгт “Зохицуулах хороо нь шийдвэрлэх асуудлаа зохицуулагчдын зөвлөлийн хурлаараа хэлэлцэнэ. Хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Тогтоолыг тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч дагаж мөрдөнө” гэж заасныг тус тус үндэслэн “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5.3.1-д заасныг баримталж Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 464 дүгээр тогтоолоор “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн тарифыг тогтоосон байна.

Тус тогтоолоор орон сууцны халаалт болон хүн амьдарч байгаа дотуур байрыг талбайн хэмжигдэхүүнээр тооцож м² -ыг 600 төгрөгөөр тооцохоор тогтоож өгсөн ч талбайн эзлэхүүнээр буюу м³-ыг 1870 төгрөгөөр тооцож төсөвт байгууллагын тарифаар халаалтын төлбөрийг авч байсныг Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5.3.1 дэх заалтад “Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилагдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно, орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзлэхүүнээр тооцно” гэж заасны дагуу Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны халаалтын хөлсийг хууль тогтоомжийн хүрээнд талбайн эзлэхүүнээр

биш, хэмжигдэхүүнээр тооцож төлөх саналыг Төрийн аудитын газраас аймгийн ИТХ-д орон нутгийн 2023 оны төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх саналд оруулсан нь дэмжигдэн хэрэгжиж, халаалтын зардлыг хэмнэхэд нөлөөлсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд зохих хэмнэлт гарсан ч хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.2 дахь заалтад “Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, 15.1.3 дахь заалтад “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” 15.1.4 дэх заалтад “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.5 дахь заалт “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.7 дахь заалт “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах” гэсэн заалтуудтай холбоотойгоор 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.5 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 23.3 сая төгрөгийн 6 албан шаардлага, 23.4 сая төгрөгийн 2 зөвлөмж, 2023 он санхүүгийн тайлангийн аудитаар 10.3 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 13.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 41.2 сая төгрөгийн 4 зөвлөмж, 2024 санхүүгийн тайлангийн 2.8 сая 3 төлбөрийн акт, 34.0 сая төгрөгийн 4 албан шаардлага өгсөн байна. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудит 2022 он

- ❖ Соёл урлагийн газар 0.7 сая төгрөгөөр видео контент хийсэн, “Өглөөлөг” сургалт, уулзалтад зориулан 0.3 сая төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авч төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан, Улаангом сумын 13 дугаар Цэцэрлэгийн арга зүйч багшид албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил болох сургалт хийсэн байхад сургалт хийсний хөлс гэж 0.1 сая төгрөг олгосонд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Засаг даргын нөөц хөрөнгөөс Өлгий сумын ЗДТГ 0.4 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Засаг даргын нөөц хөрөнгөөс Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар 2.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгсөн.
- ❖ Стандарт хэмжилзүйн хэлтэс нь сургалт зохион байгуулахтай холбогдуулан цайны материалын зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өгсөн.
- ❖ Соёл урлагийн газар төсвөөс 0.8 сая төгрөгийг 6 удаагийн сургалт, цайны зардал гаргасанд албан шаардлага өгсөн.
- ❖ Улаангом сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь эмэгтэйчүүдийн баяр, хүүхдийн баярт зориулж төсвөөс бэлгийн үнэд 1.7 сая төгрөг зарцуулсанд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.
- ❖ Мал эмнэлгийн газар нь батлагдсан бүтэц, орон тоог хэтрүүлэн 1 үйлчлэгч, 1 жолооч нэмж ажиллуулан 14.8 сая төгрөгийн цалинг төсвөөс олгосонд зөрчлийг таслан зогсоохыг албан шаардлага өгсөн.
- ❖ Нийтийн номын сан нь Соёлын сайдын 2022 оны баталсан орон тоог зөрчин архив, бичиг хэргийн ажилтан, нярав шинээр нэмж ажиллуулан төсвөөс 2.0 сая төгрөгийн цалин олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгсөн.
- ❖ Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь эрх бүхүй албан тушаалтан, байгууллагын удирдамж, хөтөлбөр, томилолтын тайлан, илтгэх хуудасгүйгээр Хөвсгөл аймгийн Мөрөн суманд ажилласан багийн Засаг дарга, ЗДТГ-ын 12 мэргэжилтний томилолтын зардалд 4.2 сая төгрөг, замын зардалд 0.8 сая, Тэс суманд ажилласан ЗДТГ-ын 20 албан хаагчдын томилолтын зардалд 3.8 сая, Цагаанхайрхан суманд ажилласан 3 мэргэжилтний томилолтын зардалд 0.6 сая, ОХУ-ын Тува Красноярскийн хязгаарын Курагино районд эрх бүхүй албан тушаалтан байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан хөтөлбөргүй, албан ёсны гэрээ хэлцэл байхгүй, томилолтын тайлан, илтгэх хуудасгүй 4 албан хаагчийн 2.8 сая төгрөг, нийт 12.3 сая төгрөгийн дотоод албан томилолтын зардал олгосонд зөвлөмж өгсөн.

- ❖ Соёл урлагийн газар нь архив-бичиг хэрэг, няравын нэг орон тоог архив-бичиг хэрэг, нярав гэсэн 2 орон тоо болгон давхардуулан ажиллаж төсвөөс 11.1 сая төгрөгийн цалинг олгосонд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудит 2023 он

- ❖ Өндөрхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2023 оны 02 дугаар сард 0.3 сая төгрөгийн урамшуулал авсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Зүүнхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15/06 дугаар тогтоолоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 төлөөлөгчид тус бүр 0.3 сая, нийт 6.0 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга нь аймгийн Засаг дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын шийдвэрүүдийг үндэслэн улирлын үр дүнгийн урамшууллын 0.7 сая төгрөгийг давхардуулан авсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр гүйцэтгэгчид олгосон цалингийн урьдчилгаа 0.3 сая төгрөгийг суутган тооцоогүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Цагаанхайрхан сумын Соёлын төвд 2021 оны 03 сард хөгжмийн багшаар ажиллаж байгаад 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Б/04 тоот тушаалаар чөлөөлөгдсөн албан хаагчид Соёлын төвийн эрхлэгчийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар хөгжмийн багш түр ажиллуулах шийдвэр гарсан боловч тухайн хөгжмийн багш ажиллаагүй гэдэг нь санхүүгийн анхан шатны баримтаар тогтоогдож 2023 оны 11, 12 дугаар сарын цалинд 2.7 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ 0.3 сая төгрөг, нийт 3.0 сая төгрөг тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Тариалан сумын Засаг даргын тамгын газрын төсвөөс ажиллагсдыг аялалд явахад нь замын зардал гэж нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 2.1 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн зөрчилд албан шаардлага өгсөн.
- ❖ Завхан сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас дотоод албан томилолт, хэвлэл, хүлээн авалтын зэрэг зардлуудад 11.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.
- ❖ Аймгийн Засаг даргын тамгын газар нь Баруун бүсийн аймгуудын нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультай, ажилтнуудын сургалт, спортын арга хэмжээнд, ирсэн зочид төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэхэд Засаг даргын нөөц хөрөнгөөс 3.3 сая, Алсын хараа-2050 хөтөлбөрийн хүрээнд Соёлын сэргэлт-2023 арга хэмжээг Увс аймагт зохион байгуулахаар ирсэн урлагийн алдартан, зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.7 сая төгрөгийн, Алсын хараа-2050, шинэ сэргэлтийн бодлогын үзэл баримтлал, “Нээлттэй Увс аймаг хөтөлбөр” хэрэгжүүлэхэд иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн дэмжлэгээс Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар 8.2 сая, нийт 14.2 сая төгрөгийн бэлэг худалдан авсан зөрчилд зөвлөмж өгсөн.
- ❖ Аймгийн Засаг даргын тамгын газар нь Төрийн архивын барилгын нээлтийн арга хэмжээнд зориулан хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулахад 160 хүний хүлээн авалтад Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.7 сая төгрөг зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.
- ❖ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2023 оны А/06 дугаар тушаалаар байгууллагын албан хаагчдын сургалт болон Барилгын удирдах ажилтны зөвлөгөөний үйл ажиллагаанд 130 хүн оролцуулж нийт 22.3 сая төгрөг зарцуулахаар баталсан байх бөгөөд гүйцэтгэлээр 21.8 сая төгрөг зарцуулсан, нийт зардлын 24 хувь буюу 5.1 сая төгрөгийг сургалтын хэрэглэгдэхүүн авахад зарцуулж, үлдэх 76 хувь буюу 16.6 сая төгрөгийг хүлээн авалт, үдийн хоол, хөнгөн зууш, цайны хэрэгсэл, ус, ундаа, кофе худалдан авахад зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.
- ❖ Сагил сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс 2023 оны А/30 дугаар захирамжаар Улаанбаатар хотод “Алсын хараа-2050” хэлэлцүүлэгт оролцох, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад нутгийн зөвлөлийн гишүүдтэй уулзахад зориулан 2.0 сая төгрөгийн 50 ширхэг бэлгийн багц худалдан авсан, 2023 оны А/42 дугаар захирамжаар эх үрсийн баярын үйл ажиллагаанд зориулан 0.2 сая төгрөгөөр 7 ширхэг цүнх, 0.02 сая төгрөгөөр 7 ширхэг цэцэг худалдан авсан, 2023 оны А/63 дугаар захирамжаар Гаадан хамбын мэндэлсний 100 жилийн ойн бэсрэг наадмын морь, бөхийн шагналд 1.0 сая төгрөг зарцуулсан, 2023 оны Б/11 дүгээр захирамжаар Засаг даргын тамгын газрын даргад цэрэг татлагын ажлыг сайн зохион байгуулсан гэж 0.4 сая төгрөгийн урамшуулал олгосон, 2023 оны А/74 дүгээр захирамжаар Монгол улсын гавьяат эмч цол тэмдгээр шагнагдсан иргэнд 2.0 сая төгрөг олгосон зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудит 2024 он

- ❖ Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар цалин шинэчлэн батлахдаа нягтлан бодогчийн ТҮ-8 ангилал буюу 1.1 сая төгрөгийн үндсэн цалинг 1.4 сая төгрөгөөр тогтоож, 1-3 дугаар сард 1.7 сая төгрөгийн цалин, урамшуулал илүү тооцон олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ❖ Түргэн сумын Соёлын төв нь Бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас 27 азтан шалгаруулж 0.4 сая төгрөгийг олгож үрэлгэн хандан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

- ❖ Малчин сумын Засаг даргын тамгын газар нь Ойрад түмний мэнд нэвтрүүлгийн төлбөрт 1.0 сая, хил залгаа сумуудтай гэрээ байгуулах ажлын хүрээнд дурсгалын зүйл худалдан авахад 3.5 сая, нийт 4.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.
- ❖ Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Малчин сумын Орон нутгийн хөгжлийн санд Тогтвортой амьжиргаа-3 төслөөс урамшуулал гэж 50.0 сая төгрөг орж ирснээс 5.0 сая төгрөгийг иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт сурталчилгаанд зарцуулахдаа 4 багийн дарга, Санхүү албаны дарга, Төсөв, төрийн сангийн мэргэжилтний данс руу гүйлгээ хийсэн зөрчилд албан шаардлага өгсөн.
- ❖ “Увс АЗЗА” ТӨХК-ийн захирлын тушаалаар албан хаагчдад 2.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг олгосон зөрчилд албан шаардлага өгсөн.
- ❖ Зүүнговь сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс 2024 оны А/28 дугаар захирамжаар морины хөшөө цогцолбор барих барималч сонгож гэрээ байгуулах, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хүмүүстэй уулзах, сургуулийн хичээлийн байрны асуудлыг шийдвэрлүүлэх, Улсын Их Хурлын гишүүдтэй уулзахад зориулан 1.5 сая төгрөгөөр 20 ширхэг бэлгийн багц худалдан авсан, А/44 дүгээр захирамжаар гавьяат барилгачинд хүндэтгэл үзүүлэхэд 2.0 сая, А/81 дүгээр захирамжаар аймгийн арсланд наадмын шууд дамжуулалт, багш нарт нь хүндэтгэл үзүүлэхэд 3,370.0 мянга, А/83 дугаар захирамжаар Өгөөмөр хайрхны овоо тахихад 0.8 сая, А/85 дугаар захирамжаар аймгийн арслан Д.Урианхайн цолны мялаалга наадамд 6.8 сая, А/86 дугаар захирамжаар адуучин тэмцээн зохион байгуулахад 2.3 сая, А/132 дугаар захирамжаар соёл, урлаг спортын арга хэмжээнд 5.6 сая, нийт 22.4 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өгсөн.

Хуулийн 15.1.3 дахь заалт “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” 15.1.5 дахь заалт “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно” гэж заасан байхад аудитын хамрах онуудад зөрчил давтан гарсаар байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Цаашид хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэн ажиллах чиглэлийг төсвийн захирагч нарт чиглэл хүргүүлэн ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагчид зөвлөв.

БҮЛЭГ:Б. Хөрөнгө оруулалттай холбоотойгоор хуульд заасан журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Б.1. Хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална”, 13.1.3 дэх заалтад “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэж заажээ.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд 2023 онд 3,311.0 сая төгрөгийн 5, 2024 онд 22,677.4 сая төгрөгийн 33, нийт 25,988.4 сая төгрөгийн 38 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Мөн 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4,245.3 сая төгрөгийн 18, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,760.0 сая төгрөгийн 16, Замын сангийн хөрөнгө оруулалтаар 745.6 сая төгрөгийн 4, 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4,100.7 сая төгрөгийн 18, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3,408.3 сая төгрөгийн 24, Замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,051.4 сая төгрөгийн 5, нийт

15,311.3 сая төгрөгийн 85 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны хэмнэлт

/сая төгрөг/

№	Төсөв захирагч	Он	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэмнэлт
1	УТХО	2023	3,311.0	3,219.2	91.8
2	ОНТХО	2023	6,750.9	6,655.8	95.0
3	УТХО	2024	22,677.4	22,432.7	244.7
4	ОНТХО	2024	8,560.4	7,339.8	1,220.7
	Нийт		41,299.7	39,647.5	1,652.2

Эх сурвалж: 2023, 2024 оны УТХО, ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ийн судалгаа, ажлын баримт

Судалгаанаас харахад Худалдан авах ажиллагааны газраас 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 5 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 91.8 сая, 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 33 худалдан авах ажиллагааг зохион байгуулж 244.7 сая төгрөгийн хэмнэлтийг тус тус гаргажээ.

Мөн 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд 38 худалдан авах ажиллагааг зохион байгуулж 95.0 сая, 2024 онд 47 худалдан авах ажиллагааг зохион байгуулж 1,220.7 сая төгрөгийн хэмнэлт гаргажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална”, 13.1.4 дэх заалтад “Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх”, 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.2 дахь заалтад “Хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ”, 13.3.3 дахь заалтад “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасан байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар хуулийн дээрх заалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ -286.4 сая төгрөгийн Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц 2 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн байхад гэрээ байгуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.
- Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/-800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.
- Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/ 1,500.0 сая, /Увс, Тариалан сум,

Увс нуур/ 1,874.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлт гараагүйгээс шалтгаалан тендер шалгаруулалт зарлаагүй зөрчилд хууль тогтоомжид нийцсэн төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж байх талаарх зөвлөмжийг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.5 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заасан байна.

Өмнөх онуудад хийсэн Санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудитаар иргэдийн саналыг аваагүй төсөл, арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитаар:

- Бөхмөрөн сум 284.4 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ,
 - Наранбулаг сум 638.5 сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.
- 2022-2023 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар:**
- Өндөрхангай сум 30.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ,
 - Бөхмөрөн 605.9 сая төгрөгийн төсөвтэй 31 төсөл, арга хэмжээ,
 - Зүүнхангай сум 116.2 сая төгрөгийн төсөвтэй 1 төсөл, арга хэмжээ,
 - Наранбулаг сум 1,362.8 сая төгрөгийн төсөвтэй 1 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

Б.2. Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагааг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2022-2024 онд төсөвт байгууллагуудаас цахим дэлгүүрээс бараа, бүтээгдэхүүн худалдан авах төлөвлөгөө ирүүлээгүй байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудын хувьд салбарын онцлогоос хамаарч боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд цахим дэлгүүрээс цөөн нэр төрлийн бараа бүтээгдэхүүний хувьд худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- Аймгийн Нэгдсэн эмнэлэг цахим дэлгүүрээс 2022 онд 598.6 сая төгрөгөөр 76 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 2023 онд 830.4 сая төгрөгөөр 83 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 2024 онд 1,226.9 сая төгрөгийн 106 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байна.
- Увс аймгийн Ерөнхий боловсролын 28 сургууль Боловсролын сайдын ерөнхий гэрээг үндэслэн цахим дэлгүүрээс 2022 онд 565.4 сая, 2023 онд 800.6 сая, 2024 онд 516.5 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.
- 2023 онд Өндөрхангай сумын цэцэрлэг 3.0 сая, Түргэн сумын цэцэрлэг 2.9 сая, Тэс сумын цэцэрлэг 3.8 сая, нийт 9.7 сая төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийсэн байна.

Бусад төсвийн байгууллагуудын хувьд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй шалтгаан нөхцөлийг санхүүгийн ажилтнуудаас тодруулахад цахим дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний сонголт бага, өртөг өндөр, захиалга цуцлагддаг, чанарын шаардлага хангадаггүй, тээврийн зардлаас эхлээд төсөвт өртөг нэмэгддэг зэргээр хүндрэл үүсдэг гэсэн тайлбарыг өгч байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтад “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэж заасныг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэн ажиллах нөхцөл бүрдээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэж заасан байна.

Худалдан авах ажиллагааны газрын 2023, 2024 оны цахим худалдан авах ажиллагаа дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Цахимаар зарласан худалдан авалт

/сая.төг/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	2023 он		2024 он	
		Төсөл арга хэмжээний тоо	Батлагдсан төсөв	Төсөл арга хэмжээний тоо	Батлагдсан төсөв
1	ТЕЗ-ын харьяа байгууллага	10	765.2	17	1,178.5
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр	23	495.0	42	7,593.5
3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	25	1,787.3	36	5,228.3
4	Замын сангийн хөрөнгөөр	2	420.6	10	1,767.7
	Нийт дүн	60	2,978.1	105	15,768.0

Эх сурвалж: /Орон нутгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан/

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар бараа, бүтээгдэхүүн худалдан авах ажиллагаатай холбоотойгоор 2023 онд 426.9 сая, 2024 онд 202.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн байна. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудит 2023 он

- ❖ Мал эмнэлгийн газар нь Биокомбинат улсын төсөвт үйлдвэрийн газраас малын эм вакцин худалдан авахдаа гэрээ дүгнэж акт үйлдэхгүйгээр 296.9 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлсэнд зөвлөмж өгсөн.
- ❖ Наранбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 55.5 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бэлтгэхдээ 4 хувааж тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийсэнд зөвлөмж өгсөн.
- ❖ Цагаанхайрхан сумын Засаг даргын тамгын газар нь 24.8 сая төгрөгийн шатах тослох материалыг тээвэр шатахууны зардлаас шууд худалдан авалт хийсэнд зөвлөмж өгсөн.
- ❖ Цагаанхайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 49.6 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бэлтгэхдээ 3 хувааж тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийсэнд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудит 2024 он

- ❖ Аймгийн Засаг даргын тамгын газар нь 77.4 сая төгрөгийн бичиг хэрэг, багаж, техник хэрэгсэл, Баруунтуруун сумын Цэцэрлэг 72.2 сая төгрөгийн хүүхдийн хоолны хүнсний материал худалдан авахдаа тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийсэнд зөвлөмж өгсөн.
- ❖ Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 20.0 сая төгрөг байхаар заасныг зөрчин үндсэн санхүүжилтийн дансаар 25.1 сая, нэмэлт санхүүжилтийн дансаар 27.4 сая, нийт 52.5 сая төгрөгийн тээвэр шатахуун худалдан авахдаа шууд худалдан авалт хийсэнд зөвлөмж өгсөн.

БҮЛЭГ:В. Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнтэй байгаа ч алдаа, зөрчил гарсаар байна.

В.1. Хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтад “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана” гэж заасан байна.

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-д заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 13/04 дүгээр “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хүрээнд 176.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 11 тээврийн хэрэгслийг холбогдох байгууллагад шилжүүлэх, төрийн байгууллагуудад ашиглаж байсан 70 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал: 2023 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 14.0 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 1,190.0 сая төгрөгийн 5 албан албан шаардлага, 1,336.4 сая төгрөгийн 16 зөвлөмж, 2024 онд 21.2 сая төгрөгийн 20 төлбөрийн акт, 33,879.6 сая төгрөгийн 23 албан албан шаардлага, 9,585.5 сая төгрөгийн 26 зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс төсөвт байгууллагуудын өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд цахимаар болон аймгийн Засаг даргын захирамжаар төлөвлөгөө батлуулан сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Харин Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2023-2024 онд Сангийн яамнаас хяналт хэрэгжүүлэх чиглэл ирүүлээгүй, удирдамж гарган тусгайлан хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023-2024 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд бие даан хяналт хэрэгжүүлээгүй, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд

төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянасан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд илэрсэн зөрчлийг ангилан бүртгэдэггүй байна.

Увс аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 8.1, 8.8 дахь заалтын дагуу тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж цахим системд тайлагнасан байна.

Тухайлбал: Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 11 заалтаас 2024 оны байдлаар “100 хувийн хэрэгжилттэй 8, 70 хувийн хэрэгжилттэй 2, 30 хувийн хэрэгжилттэй 1 заалт байна” гэж дүгнэсэн байна.

В.2. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсөвт хэмнэлт гарсан ч үр дүн хангалтгүй байна.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлээр 57,823.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 50,664.8 сая төгрөгийг зарцуулж 7,158.9 сая төгрөгийн хэмнэлттэй, 2024 санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлээр 83,694.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 74,469.4 сая төгрөгийг зарцуулж 9,225.2 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Хүснэгт 5. ТЕЗ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл

Код	Үзүүлэлт	2023			2024		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,823.72	50,664.78	7,158.93	83,694.55	74,469.39	9,225.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,440.53	13,904.07	536.46	22,900.65	22,510.62	390.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,813.11	1,719.86	93.25	2,814.55	2,694.99	119.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,894.56	10,304.53	590.03	18,059.96	15,963.89	2,096.06
2104	Хангамж, бараа материалын зардал	1,376.28	1,318.99	57.29	1,522.41	1,429.47	92.94
2105	Нормативт зардал	266.41	266.22	0.18	314.66	313.49	1.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,107.22	1,074.59	32.62	1,272.80	1,242.58	30.22
2107	Томилолт, зочны зардал	531.91	479.12	52.78	581.79	565.20	16.59

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,099.08	1,731.57	367.51	3,889.92	3,776.35	113.57
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,444.44	4,090.21	354.23	5,577.42	5,097.43	479.99
212	ТАТААС	28.00	26.70	1.30	53.80	53.80	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,477.46	1,405.64	71.82	2,304.56	2,259.24	45.32
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,399.25	12,641.86	3,757.39	22,339.51	18,019.30	4,320.21
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,945.47	1,701.42	1,244.06	2,062.52	543.00	1,519.52

Эх сурвалж: 2023,2024 оны ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, эх үүсвэр төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүйгээс санхүүжилт бүрэн олгогдоогүй, шинээр ашиглалтад орох барилга байгууламжийн тогтмол зардал хэмнэгдсэн нь зардал хэмнэгдэх гол шалтгаан болсон байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас 2022-2024 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй зөрчлүүдийг дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 6. Зөрчлийн нэгтгэл

/сая. төг/

Шийдвэр	2022		2023			2024		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	13	19.9	8	14.0	20	21.2	41	55.1	
Албан шаардлага	16	802.3	5	1,190.0	23	33879.6	44	35,872.0	
Зөвлөмж	15	6568.4	16	1,336.5	26	9585.5	57	17490.4	
Хариуцлага тооцуулах албан шаардлага	2	524.8	0	-	0	0.0	2	524.8	
Нийт	46	7,915.4	29	2,540.5	69	43,486.3	144	53,942.20	

Эх сурвалж: /ТАБ-ын статистик мэдээ/

Дээрх хүснэгтээс харахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийг төсвийн бүх шатны захирагчид зохих хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч алдаа, зөрчил давтагдан гарсаар байна.

В.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас 2022-2024 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтад “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан

мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэж заасныг зөрчсөн 48,993.7 сая төгрөгийн 59 зөрчил илрүүлсэн.

Хүснэгт 6. Шилэн дансны тухай хуулийн зөрчил

/сая.төг/

№	Он	Нийт зөрчил		Үүнээс					
				Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2022	18	7,822.1	5	753.5	1	524.8	12	6,543.7
2	2023	6	1,558.8	3	1,176.9	-		3	381.9
3	2024	35	39,612.9	13	30,513.5	-		22	9,099.4
Нийт		59	48,993.8	21	32,443.9	1	524.8	37.00	16,025.0

Эх сурвалж: /ТАБ-ын статистик мэдээ/

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 37 зөвлөмж, 21 албан шаардлага, 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгсөн байна.

Аудитын явцад түүвэрт хамрагдсан орон нутгийн өмчит 4 аж ахуйн нэгжийн 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээд санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нээлттэй хувьцаат компанид тавигддаг шаардлагын дагуу бэлтгэж эрх бүхий этгээдэд тайлагнах бөгөөд аудитын дүгнэлттэй хамт олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна” гэж заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит 4 хуулийн этгээд санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим сайт болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна” гэж заасны дагуу орон нутгийн өмчит 4 хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй мэдээлсэн байна.

Харин сонгон шалгаруулалтын үр дүн, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулаагүй байна. Цаашид Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.2-20.4 дэх хэсгийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах чиглэлийг төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
2. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт 757 тээврийн хэрэгслийн 318 буюу 42 хувь нь тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 4,460.4 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагыг хангахгүй байна.
4. Бөхмөрөн, Наранбулаг, Өндөрхангай, Зүүнхангай сумд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй 3,037.8 сая төгрөгийн 75 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.
5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, орон тоо, гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоогоогүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүтэц орон тоо, цалин хөлсний нийтлэг жишгийг батлах.

Аймгийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нарт:

2. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарт шилжүүлэх.

Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал:

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Б/34 дүгээр тушаалаар хяналт үнэлгээ хариуцсан менежерийг томилж үндсэн цалинг 1.9 сая төгрөгөөр, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Б/43 дугаар тушаалаар хүний нөөцийн бүтээмжийн менежерийг томилж үндсэн цалинг 1.8 сая төгрөгөөр тус тус тогтоосон асуудлыг нэгдсэн тайланд тусгуулах.

Увс аймаг, Улаангом-85160,

Засаг даргын тамгын газрын байр Утас:70453317

И-мэйл: uvs@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn